



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 22/05

Чойбалсан хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.30 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх) Үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь заалт, ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Баттогтохын Шатарыг улируулан сонгосугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Б.Шатар/-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн дарга сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.

ГИШҮҮД:



Ө.АМАРЖАРГАЛ

С.БАДАРЧ

Ю.БАТБААТАР

Б.БАТСАЙХАН

Ш.БАЯСГАЛАН

Н.БОЛДРАГЧАА

Ш.ИДЭР

Н.ЭНХЦЭЦЭГ



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 22/06

Чойбалсан хот

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 83 дугаар зүйлийн 83.3, 83.4, 83.6, 83.8, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.7 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шатар овогтой Баясгалан-ыг “Адуунчулуун” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар улируулан томилсугай.
2. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, гэрээний хавсралтыг шинэчлэн хянаж Төлөөлөн удирдах зөвлөлийн 05 дугаар сарын хуралд танилцуулж батлуулахыг нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

ДАРГА



Б.ШАТАР



**“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 22/07

Чойбалсан хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын
бүрэлдэхүүнийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.46, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.5.1, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3 дахь заалт, ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

а. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо:

Хорооны дарга: Өлзийхутаг АМАРЖАРГАЛ
Гишүүд: Юра БАТБААТАР
Нанзаддорж ЭНХЦЭЦЭГ
Санжаа БАДАРЧ
Баттогтох БАТСАЙХАН

б. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: Юра БАТБААТАР
Гишүүд: Өлзийхутаг АМАРЖАРГАЛ
Нанзаддорж ЭНХЦЭЦЭГ
Санжаа БАДАРЧ
Намжилцэрэн БОЛДРАГЧАА

в. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: Нанзаддорж ЭНХЦЭЦЭГ
Гишүүд: Өлзийхутаг АМАРЖАРГАЛ
Юра БАТБААТАР
Шатар ИДЭР
Шатар БАЯСГАЛАН

2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмуудыг мөрдөж,

хорооны жилийн төлөвлөгөөг ТУЗ-ийн 05 дугаар сарын хуралд танилцуулахыг хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР



**“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 22/08

Чойбалсан хот

**Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн
бичгийн даргыг томилох тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.53, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.5.7, ТУЗ-ийн Даргын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн санал, ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ойдовжамцын Гангамөрөнийг улируулан томилсугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 22/09

Чойбалсан хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны ээлжит хурлын хуваарь
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйл, ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн 2022 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д, түүнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Б.Шатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР

